Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН НЭРГҮЙ ОВОГТОЙ УРАНХАЙЧИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | СС-ын 2021 оны 04 дүгээр тушаалын дагуу тайлан хүргүүлсэн байна | - | СС-ын 2021 оны 04 дүгээр тушаалын 14,15 дугаар хавсралтын тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна | Монгол Улсын Засгийн газар, Арабын Эдийн засгийн Хөгжлийн Кувейтийн сангийн хооронд хийсэн хэлэлцээрийн дагуу 8.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Түлэнхийн төв барих-Grant No.31” төсөл хэрэгжсэн. Төслийн хүрээнд 6.8 сая ам.доллар нь А, В, С гэсэн үндсэн 3 блок барилга, 1.2 сая ам.доллар нь тоног төхөөрөмжийн санхүүжилт байхаар төлөвлөгдсөн байна. Улмаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 02 дугаар сард БА-045/2023 дугаар дүнэглтээр “В” блок, 2022 оны 05 дугаар сард БА-119/2022 дугаар дүгнэлтээр А” блокийг ашиглалтад оруулсан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад төслийн барилгыг гүйцэтгэл болон ашиглалттай танилцсан ба Салхивч агааржуулалтын системийг бүрэн | 2025.06 дугаар сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | ашиглалтанд оруулж хүлээлгэж өгөөгүй, цахилгааны нөөц үүсгэвэр болох генератор нийлүүлж суурилуулах ажил хийгдээгүй зэрэг зөрчил илэрсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсруулж байна. /70 хувь/ | | |
| 2 | Арга хэмжээ 1.2. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл арга хэмжээний мэдээллийн ODAMIS цахим системийн хөтлөлтөд хяналт тавих | Цахим системд байршуулсан мэдээллийн хяналт | - | Тайлагналын үнэн зөв, бүрэн байдал хангагдана | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийн удирдлагын систем ODAMIS-д 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2.0 сая евро, 1.9 сая иен, 0.7 сая доллар, 20,578.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг бүртгэн илгээсэн байна. Үүнээс 2.0 сая евро, 0.5 сая доллар, 18,502.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг Сангийн яам баталгаажуулсан байна. ODAMIS цахим программыг "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем-PIMIS" цахим хуудсанд нэгтгэхтэй холбоотой гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. ODAMIS болон PIMIS программын бүртгэл, мэдээлэлд хийсэн хяналтын тайланг Санхүү, эдийн засгийн газарт дотоод меморандум хүргүүлэхээр бэлдэж байна. /30 хувь/ | 2025.06-07 дугаар сар | |
| | | | | | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3 | Арга хэмжээ 1.3. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар 2021-2024 онд хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээ хийх | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу "Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл (P173799)"-ийн хэрэгжилтийн үр нөлөөний хөндлөнгийн үнэлгээний тайланг Эрүүл мэндийн сайдын 1а/2990 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 2025.03-05 дугаар сар | |
| **Зорилт 2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа** | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/528 дугаар тушаалаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж тайланг боловсруулж байна. /70 хувь/ | 2024.06 дугаар сар | |
| **Зорилт 3. Гадаадын зээл, тусламжаар нийлүүлэгдсэн өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, мэдээлэл, ашиглалт, зарцуулалтын явцын хяналт, дотоод аудит хийх үйл ажиллагаа** | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ 3.1. Сонгогдсон төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн өмч, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад дотоод аудит хийх | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | Төрийн нарын бичгийн даргын А/32 тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж ажиллан Глобаль сангийн ДОХ, сүрьегийн төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд 2024-2025 онд нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмжийн хуваарилалтад хяналт | 2025.04-05 дугаар сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | шалгалт хийлээ. Шалгалтын тайланг ажлын хэсгийн даргад хүлээлгэн өгсөн. | | |
| 6 | Арга хэмжээ 3.2. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй Сангийн яаманд бүртгэлгүй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн тайлан мэдээлэлд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх явцад Сангийн яаманд бүртгэлгүй 2023 оноос хэрэгжиж эхэлсэн 5.4 сая воны санхүүжилттэй “Монгол Улсын халдварт өвчний хяналтын тогтолцоог бэхжүүлэх-MIRACLE” төслийн тайланд хүлээн авч, үнэлгээ хийсэн. Үнэлгээний явцад Төслийн удирдах хороо байгуулагдаагүй байгаа нь цаашдаа төслийн үр нөлөөгүй хэрэгжих, давхцал үүсэх эрсдэлтэйг төслийн багт мэдэгдсэн. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/172 тушаалаар Төслийн удирдах хороо байгуулагдсан. | 2025.02-03 дугаар сар | |
| **Зорилт 4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 4.1. ЭМЯ-ны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ, аймаг, нийслэлийн ЭМГ-ийн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт- | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийн дагуу ЭМЯ-ны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газруудын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг үнэллээ. Салбарын хэмжээнд хөтөлбөрийн үнэлгээ дунджаар 73.3% буюу | 2025.02-03 дугаар сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | шинжилгээ үнэлгээ хийх | | | | “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэв. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүн, санал, зөвлөмжийг 8/2075-2096, яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг 8/2306-2329 дүгээр албан бичгээр байгууллага тус бүрт хүргүүлсэн. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Хэрэг бүртгэлийн 250601093 дугаартай хэрэг бүртгэлд шинжээчээр ажиллах | Шинжээчийн тайлан | - | Тайлан хүргүүлсэн байна. | ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11/2217 албан бичгээр шинжээч томилж, шинжилгээ хийлгэх албан бичиг ирсэний дагуу Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн 2022 оны хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд хяналт шалгалтыг хийж шинжээчийн дүгнэлтэд холбогдох мэдээллийг тусгуулсан. | 2025.02-03 сар | |
| 2 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, тайланг | Тайланг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлж, | Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа 28 төсөл арга хэмжээний 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан | 2025.01-03 дугаар сар | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | | Сангийн яаманд хүргүүлдэг | цахим мэдээллийн санд оруулсан байна. | боловсруулсан. Үнэлгээний хувь 81.8% байна. Тайланг 1а/1152 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Удирдлагын академи цахим сургалтад хамрагдах /мэдээлэл технологи/ | Сургалтын хөтөлбөр | - | Сургалтанд хамрагдсан байна | “Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс тогтоох”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй” сургалтад 2025.05.14, 16-ны өдрүүдэд оролцож, гэрчилгээ (№20250165) авсан. | 2025.05.14, 16 | |
| | | | | | Удирдлагын академын “Microsoft 365 программын хэрэглээ” сэдэвт цахим сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан. | 2025.05.20 | |
| 2 | Арга хэмжээ 2. Хариуцсан чиг үүргийн дагуу хууль эрхзүйн мэдлэг дээшлүүлэх, мэдээллийн нэгдсэн системийн сургалтад хамрагдах | Сургалтанд хамрагдсан байна | - | - | Сангийн яамнаас зохион байгуулсан “Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй” сургалтад хамрагдсан. | 2025.05.30 | |

| | | |
|---|---|---|
| ТАЙЛАН ГАРГАСАН: | | |
| Мэргэжилтэн | Н.Уранхайч / ............................ / | 2025.06.10 |
| *(Албан тушаал)* | *(Нэр, гарын үсэг)* | *(Огноо)* |